



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 9/130

Баян-Өндөр сум

Ээлжит хуралдаан
зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.6 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02/11 дүгээр тогтоолоор батлагдсан “Хуралдааны дэгийг шинэчлэн батлах тухай” тогтоолын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн Ээлжит IV хуралдааныг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр танхим, цахим хэлбэрээр зарлан хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:

1. Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө батлах тухай;
2. Гудамж талбайд нэршил олгох тухай;
3. Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2026 онд үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээг батлах тухай;
4. Аймгийн сонгуулийн хороог татан буулгах тухай;
5. Сүм, хийдийн хугацаа сунгах тухай;
6. ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай;

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит IV хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХБАТ

